



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/360

Есөнбулаг

Гадаадад албан томилолтоор
ажиллуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/345 дугаар захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг 2023 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүс нутгийн гадаад харилцааг хөгжүүлэх, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлт"-ийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжан Уйгарын өөртөө Засах орны Хами хотод аймгийн Засаг даргын орлогч Гомбосүрэнгийн Чинбатаар ахлуулсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд ажиллуулахаар томилсугай.

2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, 3,666,000 (гурван сая зургаан зуун жаран зургаан мянга) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Айлчлалыг зохион байгуулах удирдамжийг Гадаад харилцааны ямаар хянуулж, холбогдох зөвшөөрлийг авч, хэрэгжилтийг ханган ажиллах, албан томилолтын үр дүнгийн тайлан, цаашид авч хэрэгжүүлэх санал, дүгнэлтийг ирснээс хойш ажлын 3 хоногийн дотор аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, Гадаад харилцааны яаманд хүргүүлэхийг Г.Чинбатад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР


Аймгийн Засаг даргын 2023 оны 06.
дугаар сарын 26-ны өдрийн 360 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**ХАМИ АЙМАГТ АЛБАН ТОМИЛОЛТООР
АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч : Г.Чинбат (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд :
- Ш.Насан (Аймгийн Засаг даргын зөвлөх)
 - М.Алтангэрэл (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)
 - Ц.Мөнхзаяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын гадаад харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн)
 - Ц.Лувсанжамц (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
 - Т.Сүхбаатар (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
 - Д.Цэрэвсамбуу (Хилийн боомтын захиргааны Говь-Алтай аймаг дахь Бургастай боомт хариуцсан төлөөлөгч)
 - П.Авирмэд (Жаргалан сумын Засаг дарга)
 - Д.Эрдэнэжаргал (Алтай сумын Засаг дарга)
 - Ч.Дашням (Бугат сумын Засаг дарга)
 - Д.Наранбадрах (Хөхморьт сумын Засаг дарга)
 - Н.Золжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)

__оОо__

Аймгийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 30 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын утга	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Шатахууны зардал (Ландкрузер 200 маркийн 2 ширхэг автомашин)	2700	400 литр	1,080,000
2	Зочид буудлын зардал	107750 (2 хоног)	12 хүн	2,586,000
Дүн				3,666,000

___ооо___